ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 12 сарын 01 өдөр Дугаар А/223 Бат-Өлзий сум

Гэрээ байгуулах тухай

Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэг, 46 дугаар зүйлийн 46.1.4, 46.1.6 дахь заалт, Засгийн газрын 2021 оны "Босго үнэ шинэчлэн батлах тухай" 124 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар Бат-Өлзий сумын төвийн гэрэлтүүлгийн урсгал засварын ажлыг "Мөнхийн-Илч Гэрэл" хязгаарлагдмал хариуцлагатай компанитай шууд худалдан авах аргаар гэрээ байгуулан гүйцэтгүүлсүгэй.

2. "Мөнхийн-Илч Гэрэл" хязгаарлагдмал хариуцлагатай компанитай гэрээ байгуулж, гэрэлтүүлгийн засварын ажилд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Н.Бат-Эрдэнэ)-д даалгасугай.

3. Бат-Өлзий сумын төвийн гэрэлтүүлгийн урсгал засварын ажлыг 7,900,000 (долоон сая есөн зуун мянга) төгрөгийн санхүүжилтээ авахад шаардагдах материалыг бүрдүүлэн авч, гэрээний дагуу, Орон нутгийн хөгжлийн сангаас зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын гэрээт нягтлан бодогч (Б.Пүрэвсүрэн)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА С.АМГАЛАН

D:My Doc A-4 zahiramj /Zasag darga/

6 2 3 0 1 5 0 7